

“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО”-Г ФРАНЦ ХЭЛНЭЭ ОРЧУУЛСАН НЬ (П. Пеллио, М-Д. Эвэн, Р. Поп нарын орчуулгаас)

Г. Цэвэлсүрэн *

Монголын нууц товчоог франц хэлнээ хоёр удаа орчуулсан байдаг ба эдгээр орчуулгын тухай авч үзье. Францын монголч эрдэмтэн Поль Пеллио (Paul Pelliot) “Монголын нууц товчоо”-ны монгол эхийг сэргээн, латин цагаан толгойн үсгээр галиглан буулгаж, нэгээс зургадугаар бүлгийг франц хэлнээ хөрвүүлснийг нь “Монголчуудын нууц түүх” (Монгол бичвэрийг сэргээсэн нэгээс зургадугаар бүлгийн орчуулга)¹ нэртэй 1949 онд Парис хотноо хэвлэжээ. Ийнхүү “Монголын нууц товчоо”-г франц хэлээр анх орчуулсан бөгөөд П.Пеллио 1920 оноос эхлэн монгол эхийг сэргээж галиглах, орчуулах ажлаа эхэлсэн хэдий ч зөвхөн эхний зургаан бүлгийг орчуулж үлдээжээ. 1945 онд “Монголын нууц товчоо”-ны орчуулгаа дуусгаж чадалгүй тэрээр нас барсан. П.Пеллио Францын монгол судлалыг үндэслэгчдийн нэг бөгөөд монгол судлаач франц болон бусад орны олон эрдэмтдийн багш юм.

Поль Пеллиогоос хойш “Монголын нууц товчоо”-г франц хэлнээ орчуулах явдал бараг хагас зуун жил зогсонги байдалд орсон бөгөөд 1994 онд Францын монголч эрдэмтэн Мари-Доминик Эвэн (Marie-Dominique Even), Унгарын эрдэмтэн Родика Поп (Rodica Pop) нар “Монголын нууц товчоо”-г бүрэн эхээр нь орчуулж “Монголчуудын нууц түүх” (XIII зууны Монголын цаг үеийн тоолол) гэж нэрлэн “Галлимар” хэвлэлийн газраас Алс Дорнодын улс түмний уран зохиолтой танилцуулах зорилгоор ЮНЕСКО-гоос эрхлэн гаргадаг цувралд багтаан хэвлүүлжээ. Монголч эрдэмтэн Роберт Амайон (Robert Hamayon) өмнөх үгийг нь бичсэн бөгөөд уг бүтээл “Монголын нууц товчоо”-ны сүүлийн үеийн орчуулгын нэг болжээ.

П.Пеллиогийн орчуулгыг “Монголын нууц товчоо”-ны эхийг франц хэлнээ буулгасан шинжлэх ухааны орчуулга гэж үздэг. М-Д.Эвэн, Р.Поп нар орчуулгаа гүн гүнзгий судалгааны үр дүнд бий болсон бүтээл биш гэж дурьдаад ийм судалгаа нь монголчуудын талаарх хятад болон перс эх сурвалжтай нягт холбоотой байх ёстойг онцлоод “Монголын нууц товчоо”-ны франц бүрэн орчуулга байхгүйг нөхөх зорилго тавьснаа өгүүлжээ.¹

* ХУИС-ийн багш

¹ Oeuvres postumes de Paul Pelliot “Histoire secrète des Mongols” (Restitution du texte mongol et traduction des chapitres I à VI), Paris, Librairie d’Amerique et d’Orient, 1949

¹ “Histoire secrète des Mongols” (Chronique mongole du XIIIe siècle) traduit du mongol, présenté et annoté par Marie-Dominique Even et Rodica Pop, Gallimard, Collection UNESCO d’oeuvres représentatives, Série mongole publiée sous auspices de l’UNESCO et de M. Jacques Dars, p.26

“Монголын нууц товчоо”-г ийнхүү орчуулахдаа М-Д.Эвэн, Р.Поп нар францчууд, франц хэлтэн уншигчдад энэхүү чухал бүтээлийн эх хэлний нь баялгийг аль болохоор бүрэн дүүрэн гаргаж, уншихад ойлгомжтой орчуулахыг эрмэлзжээ. М-Д.Эвэн, Р.Поп нар П.Пеллио болон эрдэмтэн Б.Сумъяабаатарын үсгийн галигийг түлхүү ашигласан бөгөөд орчин цагийн монгол хэлнээ хөрвүүлсэн бүтээл, тухайлбал, 1947 онд хуучин монгол бичгэнд шүлэглэн буулгаж, 1957 онд кирилл цагаан толгойн үсгээр галигласан Ц.Дамдинсүрэнгийн хөрвүүлэг, 1990 онд хийсэн Б.Цэрэнсодномын орчуулга болон Ш.Гаадамбын орчуулгын хувилбар зэргийг ашигласан байна.

Ингээд “Монголын нууц товчоо”-ны зарим зүйлийг Поль Пеллио болон Мари-Доминик Эвэн, одика Поп нар хэрхэн орчуулсныг жишээн дээр авч үзье.

“Монголын нууц товчоо”-ны 21 дахь зүйлийн зүйрлэл *qarurun naran sara-yn kili-yer šira noqai metь* *šičabaljaju qarqu byel'e* (Л.Лигетийн галиг, цаашид Л.Л.)-г П.Пеллио *qarurun naran sara-yn kili-udr šira noqai metь* *šičabaljaju qarqu byl'г*.

гэж галиглаад франц хэлнээ дараах байдлаар ...*quand il sortait, il sortait en rampant, tel un chien jaune, dans les rais du soleil [ou] de la lune* гэж орчуулсныг эргүүлж монголчилбол **тэрээр гарахдаа шар нохой мэт мөлхөн нар [буюу] сарны туяанд гардаг байлаа** (Г. Цэвэлсүрэн эргүүлэн орчуулсан бөгөөд цаашид Г.Ц. гэнэ.) болох бөгөөд М-Д.Эвэн, Р.Поп нар *Quand il sortait, c'est en rampant, tel un chien jaune, sur un rayon de lune ou de soleil qu'il sortait.* [Тэр хүн, гарах нар сарны хилээр шар нохой мэт шарвалзсаар гарч одно. (Ц.Дамдинсүрэн, цаашид Ц.Д.) Гарахдаа [тэр хүн] наран сарны завсраар шар нохой мэт шазвалзан гарах бөлгөө. (Д.Цэрэнсодном, цаашид Д.Ц)] гэж орчуулжээ.

Орчуулгыг нь эргүүлж монгол руу буулгавал **Тэрбээр гарахдаа шар нохой мэт сар буюу нарны туяанд мөлхөн гардаг байлаа** (Г.Ц) гэж болно. Франц орчуулгад сонирхол татах хоёр зүйл байгаа бөгөөд эдгээр нь *šira noqai mltь* зүйрлэл болон *naran sara-yn kili-yer* гэхийг хэрхэн орчуулсан явдал юм. П.Пеллиогийн орчуулгад Л.Амби *šira noqai mltь* зүйрлэлийн шар зүсний гэдгийг алтлаг гэсэн байж болох юм гээд Бурханы шашны алтадсан бурхдын дүр зургийг тойруу, битүүгээр хэлсэн магад¹ гэсэн нь ташаа мэт. Учир нь дундад зууны, тухайлбал “Монголын нууц товчоо”-г зохиосон тэр үед Монгол оронд Буддын шашин дэлгэрээгүй, монголчуудын төрийн шашин нь бөөгийн шашин байлаа. Персийн түүхч Рашид аль-Дин Алун-гоо эхийн зүүдийг тайлбарлахдаа **нэгд**, нэгэн шар, тэр ч үл барам улбар шар царайтай хүний тухай дурдсан бөгөөд тэрээр амьтны бие олж, гэрийн тооноор гулсан орж ирэх нь сүнс (онгон), бөөгийн шашинтай холбогдолтой, XX зууны эхэн хүртэл Монголын зарим нутагт энэ талаар ярьдаг байсан. **Хоёрт**, гэр бүлийн харьцаанаас гадуур жирэмслэх тухай хэлж байгаа юм¹ гэж М-Д.Эвэн, Р.Поп нар тайлбарлажээ. М-Д.Эвэн, Р.Поп нар ийнхүү орчуулахдаа Д.Цэрэнсодномын үг хэллэгийн тайлбарыг харгалзсан ч П.Пеллиогийн орчуулгын санааг илүү авч үзсэн талтай гэж үзэж байна.

naran sara-yn kili-yer-г М-Д.Эвэн, Р.Поп нар Д.Цэрэнсодномын “нар сарны завсар заагаар” буюу үүр шөнийн хагацлаар биш шууд буюу *sur un rayon de lune*

¹ *Oeuvres postumes de Paul Pelliot, Histoire secrète des Mongols, Restitution du texte mongol et traduction française des chapitres I à VI, p.124*

¹ *Histoire secrète des Mongols (Chronique mongole du XIIIe siècle) traduit du mongol, présenté et annoté par Marie-Dominique Even et Rodica Pop, Gallimard, p.256*

ou de soleil [үгчилбэл *сар эсхүл нарны (нэг) туяа(дээр)-гаар*] гэсэн нь П.Пеллиотой адил [*dans les rais du soleil (ou) de la lune*] буюу үгчилбэл нар [буюу] сарны туяа (дотор) нд] гэж орчуулсан бөгөөд завсар зааг гэснийг франц орчуулгад гурван орчуулагч тусгалгүй нар буюу сарны гэж орхин **солилт** хийн орчуулжээ. Ингэхдээ хятад орчуулгын “орж ирсэн гэрлээр” гэснийг илүү тусгажээ. **Орхилт, солилт** хийхдээ франц болон франц хэлтэн хүмүүсийн сэтгэлгээнд тохируулахыг эрмэлзэн ийнхүү орчуулжээ.

Дараагийн 22 дахь зүйлийн *tere niji'el mьsьt mety ken-e ber kilbar-a quuldaqun ta tere цuqtai mьsьt mety qamtu niken eyeten bolu'asu ken'e ber kilbar-a yekin bolqun ta ke'ebi* (Л.Л.) бөгөөд П.Пеллио тгдг niji'dl mьsьt mдть кдн-д бдг knlbar-a quuldaqun ta. тгдг цuqtai mьsьt mдть qamtu nikдн дудтдн болу'asu кдн-д бдг knlbar-a удкин болqun та кд'дби. гэж галиглаж, *Tel les cinq bois de fliches de tout a l'heure, si vous ktes chacun seul, il sera facile a quiconque de vous briser comme chacun de ces bois de fliches, si vous ktes ensemble et d'accord commun comme ces bois de fliches liьs, a qui donc serait-il facile de vous [dйtruire]?* гэж орчуулсныг нь монголчилбол **Саяын таван сүм мэт хэрэв та нар ганц ганцаар байвал та нарыг эдгээр таван сүм мэт нэг нэгээр хэн хүнд хугалахад хялбар, хэрэв та нар хамтдаа болон нэгэн санаатай байвал, хэн та нарыг хялбар [эвдэх] вэ?** (Г.Ц.) гэж болох юм.

М-Д.Эвэн, Р.Поп нар энэхүү зүйрлэлийг *Si vous ktes chacun seul, comme ces cinq bois de fliches, comme eux, quiconque pourrait aisйment vous briser. Mais si, comme ce faisceau de bois de fliches, vous ktes unis et en bonne entente, qui pourrait aisйment vous briser?* [Та нар ганц ганцаар салбал нэжээд сүм мэт хүнд хялбархан дийлэгдэнэ. Та нар эв ээ нэгтгэвэл, тэр багласан таван сүм мэт бэх болж хэнд ч хялбар дийлэхгүй болно (Ц.Д.) Тугарын (саяын) таван мөсөд (сүмны мод) мэт ганц болбол тэр нижиэл (нэг нэг) мөсөд мэт хэнд ч хялбар хугалагдана та нар. Тэр цугтай мөсөд мэт нэг эетэн болбол хэнд ч хялбар яаж болох (ялагдаж), та нар гэв (Ш.Гаадамба, цаашид Ш.Г.) Та нар саяын таван сүм мэт ганц ганцаар болвол түрүүчийн сүм мэт хэн бүхнээ хялбархан дийлэгдэнэ. Тэр багцалсан сүм мэт хамт нэгэн эеэр явбаас та нар хэнд ч яахан хялбархан үл дийлэгдэнэ (Д.Ц)] гэж орчуулсан бөгөөд орчуулгыг монгол хэл рүү эргүүлэн орчуулбал **Хэрэв та нар эдгээр таван сүм мэт ганц ганцаар байвал энэ сүмнүүд шиг та нарыг хэн бүхэн хялбархан хугалж чадна. Хэрэв энэ багц сүм мэт нэгдмэл болон эвсэг сайн байвал та нарыг хэн хялбархан хугалах вэ дээ?** (Г.Ц.) болно.

П.Пеллио болон М-Д.Эвэн, Р.Поп нар *mьsьt mety* зүйрлэлийг **модон сүм мэт** гэж орчуулсан бөгөөд *niken eyeten bolu'asu* гэснийг П.Пеллио **хамтдаа болон нэгэн санаатай**, М-Д.Эвэн, Р.Поп нар **нэгдмэл болон эвсэг сайн** гэж тус тус орчуулжээ. Зүйрлэлийн *mety-г* П.Пеллио *tel* болон *comme*, М-Д.Эвэн, Р.Поп нар *comme* холбоцын тусламжтай орчуулав.

Эдгээр зүйрлэлийг үлэмж иш татдаг бөгөөд орчуулахад бэрхшээл гараагүй бололтой. Гагцхүү *mьsьt mety* гэснийг сүм гэсэнгүй **модон сүм** гэж **нарийвчлан тодруулалт** хийж орчуулжээ. Франц хэлээр нум сумын сум, юмыг заах сум адил *une fliche* гэдэг. Иймээс нум сумны тухай гэдгийг тодруулахын тул *bois de fliche(s)* - модон сүм буюу сүмны мод гэжээ.

Дараагийн зүйрлэл “Монголын нууц товчоо”-ны 31 дэх зүйлд хамааралтай. Л. Лигетти дараах байдлаар *hцrene ьmere* [19b]-e-е *kei bolu'asu qarцpqi-bar barn'uluqsan noquit galawud-un цдьн ньсьн anu burqaliq časun mety butaraju keyisь iremь ede oyira* буюу галигласан бол П.Пеллио *hцгднд ьмгдг-дөд кдi bolu'asu qarцqi-bar bari'uluqsan noquit galawud-un цдьн ньсьн anu burqalнq časun mдть butaraju*

kdysisj irdmu ddd oupra byujd. гэж галиглан ...mais quand le vent souffle du Nord-Ouest, les plumes et le duvet des canards et des oies qu'il fait prendre a son йpervier viennent [ici] dispersйs et chassйs comme la neige dans une tempkte гэж орчуулсан бөгөөд үүнийг эргүүлэн орчуулбал ...гэвч баруун-умараас салхи үлээхэд харцагаараа бариулсан галуу, нугасны өд болон сөд шүүрган дахь цас шиг бутран хийсэж (энд, ийн) ирнэ (Г.Ц.) гэж болох юм.

М-Д.Эвэн, Р.Поп нар энэхүү зүйрлэлийг франц хэлнээ дараах байдлаар Lorsque souffle le vent du nord-ouest, le duvet et les plumes des canards et des oies que son autour a attrapйs volent jusqu'ici comme flocons de neige dans la tempkte. [Баруун хойноос салхи салхилбал түүний харцагаар бариулсан нугас, галууны өд сөд нь цас мэт бутарч хийсэж ирнэ. (Ц.Д.) Баруун хойноос салхи салхилахад харцагаар бариулсан нугас, галуудын өд сөд нь цас бургинах мэт бутарч хийсэж ирнэ.(Д.Ц.)] гэж орчуулсан бөгөөд үгчлэн монголчилбол Баруун-умарын салхи үлээхэд, түүний харцагын барьсан галуу, нугасны сөд болон өд шүүрганаар орох лавс цас мэт энд хүртэл хийсдэг (Г.Ц.) болох юм.

burqaliq ёsun metь зүйрлэлийг П.Пеллио comme la neige dans une tempkte буюу шүүрган дахь цас шиг, М-Д.Эвэн, Р.Поп нар comme flocons de neige dans la tempkte буюу шүүрганаар орох лавс цас мэт гэж тус тус орчуулсан бөгөөд харьцуулбал М-Д.Эвэн, Р.Поп нар илүү **нарийвчлан** орчуулж, Д.Цэрэнсодномын орчуулгыг харгалзан үзжээ. flocons de neige нь лавс гэх бөгөөд малгайлан орсон цасны том ширхэгийг хэлнэ¹. М-Д.Эвэн, Р.Поп нарын орчуулгад энэхүү тайлбарыг оруулбал Баруун-умарын салхи үлээхэд түүний харцага барьсан галуу, нугасны сөд болон өд шүүрганаар малгайлан орсон цасны том ширхэг мэт энд хүртэл хийсдэг (Г.Ц.) болох юм.

"Монголын нууц товчоо"-ны 41 дэх зүйлийн дараахь зүйрлэлийг Л.Лигети Ciduqul-buцц emes olotu bye'e кц'ьп inu mene metь tцrele галиглан буулгасан. Л.Лигетийн галигт цэг таслал үгүй билээ. Зүйрлэлийг П.Пеллио Ѕnduqul-buцц dмds olotu byд'д. кц'ьп ппц тдпд тдть тцгдвд. гэж галиглахдаа өгүүлбэрийг зааглан цэг тавьжээ. Түүний Ѕnduqul-buцц eut beaucoup de femmes, et ses fils naissent comme a chaque instant. орчуулсныг үгчлэн монголчилбол Чидхүл бөх олон эхнэртэй бөгөөд (түүний) хөвгүүд нь хором бүр төрөх (гарах) мэт(Г.Ц.) юм.

М-Д.Эвэн, Р.Поп нар зүйрлэлийг C'est son fils Ciduqul-le-Lutteur, qui eut beaucoup d'йrouses et dont la progйniture naissait en vaste nombre. [Зүтгэл бөх олон эм авсан тул хөвүүн нь манан мэт (олон) төрөв. (Ц.Д.) Чидхүл бөх эмс олонтой бөлгөө. Хөвүүд нь мэнэ мэт [олон] төрөв.(Д.Ц.)] гэж орчуулсан бөгөөд монголчилбол дараах болно. Түүний хүү Чидхүл бөх олон эхнэртэй бөгөөд (ач)үр нь олноор (олон буюу өргөн тоогоор) төрж байлаа. (Г.Ц.)

mene metь зүйрлэлийн олон гэсэн санааг П.Пеллио утгачлан a chaque instant буюу хором бүр гэж орчуулсан бол М-Д.Эвэн, Р.Поп нарын en vaste nombre-г үгчилбэл өргөн тоогоор болох бөгөөд кц'ьп inu-г тэд la progйniture (ач үр, удам) гэж орчуулсан нь олон гэсэн утгыг тодруулсан орчуулга болжээ. Нөгөөтэйгүүр, mene гэснийг Мэнэнгийн талтай ямар нэгэн байдлаар холбон Чидхүл бөхийн хөвгүүдийг өргөн олноор төрөв гэсэн байж болзошгүй. Учир нь Мэнэн Баарин овогтны овгийг М-Д.Эвэн, Р.Поп нар les Vastes-Enlevйs гэж орчуулахдаа Мэнэн-ийг Vastes буюу өргөн, уудам гэжээ. П.Пеллио mene metь зүйрлэлийг **нарийвлан тодруулж**, М-Д.Эвэн, Р.Поп нар **дүрслэл хийж, тайлбарлан** орчуулжээ.

¹ Я.Цэвэл, Монгол хэлийн товч тайлбар толь, УБ, 1972, 319 дэх тал

П.Пеллио болон М-Д.Эвэн, Р.Поп нар “Монголын нууц товчоо”-н дахь дундад зууны монголчуудын ахуй амьдрал, зан заншил, уламжлалын өвөрмөц онцлогийг заасан зүйрлэлийг франц хэлнээ хөрвүүлэхдээ эх зохиолын дүрслэл, агуулгыг франц хэлнээ төгс гарган, зохиол дахь соёл иргэншил, сэтгэлгээтэй холбоотой ялгааг гаргахын зэрэгцээ, франц хүний сэтгэлгээнд тохируулж, тодорхой ассоциац үүсгэн орчуулсан гэж үзэх үндэслэлтэй.

“Монголын нууц товчоо”-ны П.Пеллио, М-Д.Эвэн болон Р.Поп нарын хоёр орчуулга нь утга төгөлдөр (адекват) орчуулга юм. Хоёр орчуулга орчуулгын хэлбэрийг тохируулах, хэм, хэмжээ болон агуулгыг тохируулах, үүргийн хувьд дүйлгэх үзэл баримтлалын элементүүд орсон. Энэ нь “Монголын нууц товчоо”-ны франц хэлээр орчуулсан орчуулганд бүхэлд нь хамааралтай гэж хэлж болох талтай. Үүний сацуу П.Пеллиогийн орчуулга орчуулгын ноорог мэт сэтгэгдэл төрж байсан бөгөөд орчуулагч хийснээ эргэн харж, сайжруулах бодолтой байсан бололтой.

Ном зүй

Монгол хэлээр

1. Р.Гүрбазар, Орчуулгын онол, дадлагын үндэс, Улаанбаатар, 1996
2. Ц.Дамдинсүрэн, Монголын нууц товчоо, УХГ, Улаанбаатар, 1990
3. Л.Манлажсав, “МНТ”-ны үг хэллэгийн орчуулга, Mongolica, 2004
4. Б.Сумъяабаатар, Монголын нууц товчоо, үсгийн галиг, Улаанбаатар 1990
5. Ц.Сүхбаатар, Монгол хэлний найруулга зүй, Улаанбаатар, 1998
6. Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар, 1966
7. Д.Цэрэнсодном, “Монголын нууц товчоон”-ы орчуулга, тайлбар, Улаанбаатар, 2000
8. Б.Чулуундорж, Монгол хэлийг төрөл бус хэлтэй зэрэгцүүлэн судлахын оршил, Улаанбаатар, 2004

Орос хэлээр

9. В.Г.Гак, Б.Б.Григорьев, Теория и практика перевода, Москва, 2000
10. А.Лилова, Введение в общую теорию перевода, София, 1981
11. Mongolica: К 750-летию “Сокровенного сказания”, Москва, 1993
12. Советский энциклопедический словарь, Москва, 1982
13. Г.В.Чернов, Теория и практика синхронного перевода, Москва, 1978
14. А.В.Федоров, Основы общей теории перевода, Москва, 1968

Франц хэлээр

15. Histoire secrète des Mongols (Mongghol-un ni'uca tobciyan), traduit du mongol präsenti et annoté par Marie-Dominique Even et Rodica Pop, Gallimard
16. A.Mostaert, Sur quelques passages de l'Histoire secrète des Mongols, Arlington, Virginia, (Suite)1, HJAS 13 (1950)
17. G.Mounin, Clefs pour la linguistique, Editions 10/18, 1968
18. P.Pelliot, Oeuvres postumes de Paul Pelliot, Histoire secrète des Mongols, Restitution du texte mongol et traduction française des chapitres I a VI, Paris Librairie d'Amürique et d'Orient Adrien-Maisonnète, 1949
19. Petit Larousse illustré, Paris, 1980
20. N.Steinberg, Grammaire française, Moscou, 1966

Англи хэлээр

21. L.Ligeti, “A mongolok titkos története”, Budapest, 1964
22. I. de Rachewiltz, Index of the Secret history of the Mongols, Indiana University Publications, Uralic and Altaic Series, Vol.121, Bloomington, 1971